

ИХ, ДЭЭД СУРГУУЛИУДЫН ХУУЛЬ САХИУЛАХ БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР: ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА, ЧИГ ХАНДЛАГА



Хууль сахиулах боловсрол олгох сургалтын хөтөлбөр

Б.Энхболд

Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, доктор, дэд профессор

B.Enkhbold

Commissioner, The National Human Rights Commission of Mongolia, Doctor, associate Professor

*хариуцлагатай зохиогч: commissioner6@nhrcm.gov.mn

Хураангуй: Энэхүү судалгаа нь хууль сахиулах боловсрол олгож буй гадаадын зарим орны их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, онцлог, ач холбогдлыг нээн илрүүлэх, Монгол Улсад хэрэгжүүлэх боломжийн талаар дүгнэлт, санал дэвшүүлэхэд чиглэгдсэн бөгөөд энэ хүрээнд 9 улсын 27 их, дээд сургуулийн хөтөлбөрт дүн шинжилгээ хийсэн. Судалгааны үр дүнд үндэслэн хууль сахиулах боловсролыг хөгжүүлэх, мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Гэмт хэрэг судлал”, “Цагдаа судлал”-ын бакалавр, магистр, докторын сургалтын хөтөлбөрийг иргэний их, дээд сургуулиудад хэрэгжүүлэх боломжтой бөгөөд олон талын ач холбогдолтой гэж дүгнээд, тодорхой санал дэвшүүлсэн болно.

Түлхүүр үг: Их дээд сургууль, Хууль сахиулах боловсрол, Гэмт хэрэг судлал, Цагдаа судлал, Сургалтын хөтөлбөр, хууль сахиулагч.

Keywords: University and college, Law Enforcement Education, Criminology, Police studies, Educational Program, Law Enforcement

1. Удиртгал

Хууль сахиулах салбарын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, олон нийтийн итгэлийг хүлээж ажиллахад хууль сахиулах боловсролын гүйцэтгэх үүрэг чухал юм. Манай улсад хууль сахиулах боловсролын талаар судалгаа шинжилгээний ажил тасралтгүй хийгдэж, үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион, хэлэлцүүлэг зохион байгуулж, идэвхтэй оролцож байгаа нь эерэг өөрчлөлтүүдийг бий болгож байна.

Хууль сахиулах боловсролын судлагдсан байдлаас үзэхэд энэ чиглэлийн судалгааны ажил, боловсрол олгох онол, практикийн асуудлыг хөгжүүлэхэд төрийн мэдлийн хууль сахиулах чиглэлийн сургууль, тус салбарын эрдэмтэн, судлаачдын үзэл баримтлал, судалгааны бүтээлүүдэд тулгуурлан хийсэн дүгнэлт санал ихээхэн хувийг эзэлж байна. Харин хууль сахиулах боловсрол олгоход иргэний их дээд сургуулийн гүйцэтгэх үүрэг, хөтөлбөрийн онцлог, төгсөгчдийг хууль сахиулах салбарт бэлтгэх агуулга, мөн чанарын талаар харьцангуй бага судлагдсан нь дүгнэгдэж байна. Иймд хууль сахиулах боловсрол олгоход иргэний их дээд

сургууль, эрдэмтэн судлаачдын гүйцэтгэх үүрэг, ач холбогдлын талаар судалгаа шинжилгээний ажлыг эрчимжүүлэх шаардлага тулгарч байгаа юм.

Энэхүү судалгааны ажлын зорилго хууль сахиулах боловсрол олгож буй гадаадын зарим их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, төрийн мэдлийн хууль сахиулах сургуулиудаас ялгагдах онцлог, ач холбогдлыг нээн илрүүлж Монгол Улсад хэрэгжүүлэх боломжийн талаар дүгнэлт хийж, санал дэвшүүлэхэд чиглэгдсэн болно. дэвшүүлсэн зорилгын хүрээнд 1/Хууль сахиулах боловсролын агуулга, тогтолцоо, 2/Хууль сахиулах боловсролын түүхэн хөгжлийн тойм, 3/Монгол Улсад хууль сахиулах боловсрол олгох, хууль сахиулагчийг бэлтгэж буй өнөөгийн байдал, 4/Иргэний их, дээд сургуулийн хөтөлбөрийн онцлог, ач холбогдол, 5/Монгол Улсад иргэний их, дээд сургуулиудад “Гэмт хэрэг судлал”, “Цагдаа судлал” хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломж, хэрэгцээ гэсэн асуудлыг судалсан.

Судалгааны ажлын хүрээнд АНУ, БНСУ, ХБНГУ, Их Британи Улс БНФУ, Испани Улс, БНХАУ ОХУ зэрэг 9 улсын 27

их, дээд сургуульд (хавсралт) хэрэгжиж байгаа “Хууль сахиулах”-ын боловсрол олгох хөтөлбөр, эрдэмтэн, судлаачдын 30 гаруй бүтээл, Дотоод хэргийн их сургуулийн цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон шинжлэн магадлахуйн хөтөлбөр, холбогдох статистик, баримт материалд харьцуулалт хийх, дүн шинжилгээ хийх аргыг ашиглаж нэгдсэн дүгнэлт, санал гаргасан болно.

Энэ судалгаа нь зөвхөн иргэний их, дээд сургуульд хэрэгжүүлж байгаа хууль сахиулах боловсрол олгох хөтөлбөрийн агуулга, ач холбогдлыг нээн илрүүлэхэд чиглэгдсэн болно.

2. Хууль сахиулах боловсролын агуулга, тогтолцоо

Олон улсын төвшинд хууль сахиулахын боловсрол гэсэн ойлголт түгээмэл хэрэглэдэг бөгөөд англи хэлэнд “The law enforcement education” гэж орчуулагдаж байна. Судалгааны бүтээл, эрдэмтэн судлаачдын дүгнэлт, олон улсын хандлагаас үзэхэд хууль сахиулах боловсролыг өргөн болон явцуу утгаар тодорхойлох хандлага байна (Sapp, 1990). **Өргөн утгаар авч үзвэл**, иргэдэд хууль сахиулах боловсрол олгох, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах, иргэдийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн шинжлэх ухааны мэдлэг бүтээх, хэрэглээнд нэвтрүүлэх, дадал, чадвар олгох цогц ойлголт. Харин **явцуу утгаар авч үзвэл**, хууль сахиулах салбар тухайлбал, цагдаагийн алба хаагч, мөрдөгч, шинжээч, хорих ял, шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон хууль сахиулах бусад салбарын алба хаагчдыг бэлтгэхэд чиглэсэн шинжлэх ухааны мэдлэг олгох, сургах үйл явцыг хэлнэ.

Хууль сахиулах боловсролын агуулга нь практик сургалт, онолын сургалт, тусгай мэдлэгийн сургалтаас бүрддэг бөгөөд эдгээр агуулгыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн олгох сургалтын хөтөлбөрөөр тухайн боловсролыг олгодог байна (Edwards, 2019). Сургалтын хөтөлбөрт багтсан хичээлийн агуулгыг авч үзвэл, 1/ практик сургалт, 2/ онолын сургалт, 3/ тусгай мэдлэг олгох сургалтаас бүрддэг байна.

Хууль сахиулах боловсрол олгох институт, хөтөлбөрийг авч үзвэл, 1/ Цагдаагийн академи, коллежийн хөтөлбөр, 2/ хууль сахиулах сургуулийн хөтөлбөр, 3) иргэний их, дээд сургуулийн хөтөлбөр, 4) хууль сахиулах сургалтын төв, үргэлжилсэн болон мэргэжлийн сургалтын хөтөлбөрөөс бүрдэж байна (Garner, 1999).

Цагдаагийн академи, коллежийн хөтөлбөрт хууль сахиулагчийг бэлтгэхэд чиглэгдсэн практик болон тусгай мэдлэг олгох сургалт багтдаг бөгөөд ихэвчлэн эрчимжүүлсэн сургалтаар мэргэжлийн диплом, зарим тохиолдолд дээд боловсролын зэрэг олгодог байна. Судалгаанаас үзэхэд дэлхийн ихэнх улсад хууль сахиулагч бэлтгэх чиг үүрэг бүхий академи, коллеж үйл ажиллагаа явуулдаг байна (Carlan, 2009).

Хууль сахиулах сургуулийн хөтөлбөрт дээд боловсролтой хууль сахиулагч бэлтгэхэд чиглэгдсэн төрийн мэдлийн сургалтын институт багтдаг бөгөөд бакалавр, магистр, докторын зэрэг олгох хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байна. Тухайлбал, БНСУ-ын Үндэсний цагдаагийн их сургууль, БНФУ-ын Үндэсний цагдаагийн их сургууль гэх мэт.

Иргэний их, дээд сургуулийн хөтөлбөрт хууль сахиулахын боловсрол олгоход чиглэсэн хөтөлбөр хамаардаг бөгөөд харилцан адилгүй нэршилтэй байна. Интернэт орчинд хайлт хийж үзэхэд, “Гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо ба аюулгүй байдал”, “Гэмт хэрэг судлал” “Цагдаагийн удирдлага”, “Цагдаа судлал” “Хууль сахиулах удирдлага” гэх мэт 20 гаруй нэршил бүхий хөтөлбөр илэрч байх ба агуулгын хувьд бакалавр, магистр, докторын төвшинд сургалт явуулж байна (Paoline, 2007). Өөрөөр хэлбэл, дэлхийн улс орнуудад хууль сахиулах, цагдаагийн судлалын чиглэлээр боловсрол олгодог 100 гаруй иргэний их дээд сургууль үйл ажиллагаа явуулж, хууль сахиулах боловсролыг өргөн хүрээнд олгож байна. Үүнд, АНУ-ын Мичиганы их сургуулийн “Гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо ба хууль сахиулах ажил”, БНСУ-ын Кёнгги Их сургуулийн “Цагдаагийн удирдлага, нийтийн аюулгүй байдал”-ын хөтөлбөр, Их





МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ САХИУЛАХУЙН БОЛОВСРОЛ СУДЛАЛ

Британийн Лестерийн их сургуулийн “Цагдаагийн удирдлага, менежмент”-ын хөтөлбөрийг дурдаж болохоор байна. Цаашид “Гэмт хэрэг судлал”, “Цагдаа судлал”-ын хөтөлбөр гэх/ Хавсралтаас үзнэ үү.

Хууль сахиулах сургалтын төв, үргэлжилсэн болон мэргэжлийн сургалтын хөтөлбөрт хууль сахиулах салбарын офицер, ахлагч суралцдаг бөгөөд дараагийн шатны албан тушаалд шаардлагатай сургалтын багтдаг. Тухайлбал, мөрдөн шалгах арга зүй, удирдлагын манлайлал, шинэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чадвар гэх зэргийг дурдаж болно.

Дээрх агуулгаас үзэхэд хууль сахиулах боловсролыг төрийн мэдлийн хууль сахиулах чиглэлийн тусгай сургуулиуд олгохоос гадна иргэний их, дээд сургуулийн хөтөлбөрөөр олгож, хууль сахиулах салбарын онол, практикийг хөгжүүлэх, хүний нөөцийг бүрдүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэдэг байна.

3. Хууль сахиулах боловсролын түүхэн хөгжлийн тойм

Хууль сахиулах боловсролын агуулга нь нийгмийн өөрчлөлт, иргэдийн ухамсар, техник технологийн хөгжил, алба хаагчийн мэргэших шаардлагаас шалтгаалан түүхэн цаг хугацааны явцад хөгжиж ирсэн нь судлаачдын бүтээлээс харагдаж байна (А, 2021). Судалгааны дүгнэлтүүдэд үндэслэн дэлхийн улсуудад хууль сахиулах боловсрол хөгжиж ирсэн түүхэн хөгжлийг дараах үечлэлд хуваан үзэж болохоор байна.

I. Туршлагад суурилсан мэдлэгийн үе (1900 оноос өмнөх үе)

II. Хууль сахиулах боловсрол олгож эхэлсэн үе (1900-1945 он)

III. Хууль сахиулах боловсролыг мэргэжлийн түвшинд хөгжүүлсэн үе (1946-1970 он)

IV. Шаталсан боловсролын тогтолцоо, стандарт тогтоосон үе: (1971-1990 он)

V. Шилжилт, шинэ үеийн хууль сахиулахын боловсрол (1990 хойш)

Хууль сахиулах боловсролын түүхэн хөгжлөөс үзэхэд хууль сахиулах дээд

боловсрол олгох сургалтыг 1) Ихэвчлэн иргэний их, дээд сургууль хэрэгжүүлдэг АНУ-ын загвар, 2) Иргэний их, дээд сургууль болон төрийн мэдлийн цэргийн зохион байгуулалт бүхий сургууль хэрэгжүүлдэг холимог хэлбэрийн Европ-Азийн загвар, 3) Төрийн мэдлийн цэргийн зохион байгуулалт бүхий сургууль хэрэгжүүлдэг ОХУ, БНХАУ-ын загвар гэсэн гурван тогтолцоо бүрдсэн бөгөөд загвар бүр өөрийн давуу болон сул талтай байна. Монгол Улсын хувьд хууль сахиулах боловсрол олгох тогтолцооны өнөөгийн байдал нь гурав дахь буюу сүүлийн загвартай илүү төстэй байна.

4. Монгол Улсад хууль сахиулах боловсрол олгох, хууль сахиулагчийг бэлтгэж буй өнөөгийн байдал

Монгол Улсын Дотоод хэргийн их сургуульд хууль зүй, дотоод хэрэг, онцгой байдлын салбарын мэргэжилтнийг бакалаврын түвшинд сургаж бэлтгэхээс гадна, магистр болон докторын зэрэг олгох сургалтыг зохион байгуулж байна. Тус сургууль нь 1934 онд БНМАУ-ын Ардын сайд нарын зөвлөлийн /хуучин нэрээр/ 8 дугаар тогтоолоор “Төв сургууль” нэртэйгээр байгуулагдаж 90 жилийн хугацаанд цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, онцгой байдал, хилийн цэрэг, дотоодын цэрэг болон хуульчдыг бэлтгэж ирсэн Монгол Улсын ууган сургуулийн нэг болох судалгааны бүтээлүүдээс дүгнэгдэж байна.

Дотоод хэргийн их сургуулийн Ахлагчийн сургуульд Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын захиалгаар цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ахлагч бүрэлдэхүүний тодорхой мэргэжлээр 2 сараас нэг жилийн хугацаанд бэлтгэж мэргэжлийн боловсрол олгож байна. Харин Цагдаагийн сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль, Шинжлэн магадлахуйн институт Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/343 дугаар тушаалын хавсралтад зааснаар дараах хөтөлбөрөөр бакалаврын боловсрол олгож байна. Үүнд:

Сургуулийн нэр	Хөтөлбөрийн нэр	Олгох зэрэг	Суралцах хугацаа	Мэргэжил
Цагдаагийн сургууль	- Цагдаа судлал - Мөрдөх алба - Кибер гэмт хэрэг судлал	Бакалавр	4 жил	Аюулгүй байдал хангах үйлчилгээ /Иргэний өмч хөрөнгө хамгаалах/
	- Эдийн засгийн мөрдөгч - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил - Замын хөдөлгөөний аюулгүй байдал		2 жил	
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль	- Шүүхийн шийдвэр гүйцэтгэл - Нийгмийн ажил	Бакалавр	4 жил	
Шинжлэн магадлахуйн институт	- Шинжлэн магадлахуй	Бакалавр	4 жил	



Дотоод хэргийн их сургууль

Цагдаа, шүүхийн шийдвэр, шинжлэн магадлахуйн 4 жилийн хөтөлбөрт тусгай шалгуур хангасан 18 насанд хүрсэн, бүрэнд дунд боловсролтой иргэдийг сургаж байгаа бол цагдаагийн сургуулийн 2 жилийн хөтөлбөрт их, дээд сургууль төгссөн иргэдээс сонгон шалгаруулж суралцуулах бөгөөд Аюулгүй байдал хангах үйлчилгээ /Иргэний өмч хөрөнгө хамгаалах/ мэргэжлээр бакалаврын боловсролын зэрэг олгож байна. Мөн “Гэмт явдал судлал”, “Цагдаа судлал”, “Шинжлэн магадлахуй” магистр, докторын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж ахисан түвшний боловсрол олгодог байна. Түүнчлэн Удирдлагын сургуульд “Хууль сахиулах удирдлага”, “Цагдаагийн стратеги-тактик, удирдлага”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн стратеги-тактик, удирдлага” мэргэжлүүдээр магистр, “Хууль сахиулах удирдлага” чиглэлээр докторын хөтөлбөрийг тус тус хэрэгжүүлж удирдах төвшний хүний нөөцийг бэлтгэж байна.

Дээрх хөтөлбөрүүд нь үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, иргэдийн аюулгүй байдлыг хангах мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний хөгжлийн суурь ур чадвар, цагдаагийн албаны чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах эрх зүй, эрүүл мэнд, бие бялдар, сэтгэл зүйн болон ёс зүй, харилцааны ур чадварыг онол болон практиктай хослуулан хэрэглэх чадварыг

эзэмшдэг бөгөөд аль ч төвшиндөө “Эрх зүйч” мэргэжлийн боловсрол олгодоггүй байна.

Дотоод хэргийн их сургууль нь 3000 сонсогчийн хичээлийн төв байр болон 850 сонсогчийн байр, номын сан, спорт цогцолбор, сургалт-дадлагын төв зэрэг сургалтын орчныг бүрдүүлсэн бөгөөд цаашид “Оюутны хотхон” хэлбэрээр хөгжих нөхцөлийг бүрдүүлжээ.

Холбогдох хөтөлбөр мэргэжлийн чиглэлээр жилд дунжаар Цагдаагийн сургуулийг 300, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийг 60, Шинжлэн магадлахуйн институтийг 10, Ахлагчийн сургуулийг 600 орчим сонсогч төгсдөг бол магистр, докторын сургалтыг 60, нийт 1000 орчим хууль сахиулагч шаталсан боловсролын тогтолцоогоор бэлтгэн гаргадаг бол 90 жилийн хугацаанд Дотоод хэргийн их сургууль 50 гаруй мэргэжлээр 60.000 гаруй мэргэжилтэн бэлтгэсэн (Дотоод хэргийн их сургуулийн төгсөгчдийн мэдээлэл) хууль сахиулах салбарын сургалт, эрдэм шинжилгээний төв болон хөгжжээ. Төгсөгчдийн 98 орчим хувь нь цагдаа, шүүхийн шийдвэр, шүүхийн шинжилгээ зэрэг төрийн тусгай чиг үүргийн байгууллагад ажиллаж байгаа ч хууль сахиулах салбарын хүний нөөцийг бүрдүүлэхэд хүрэлцдэггүй болох нь судалгаанаас дүгнэж байгаа юм.

Иргэний их, дээд сургууль төгсөгчдөөс хууль сахиулах салбарт тухайлбал, цагдаа,



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ САХИУЛАХ
УНДЭСНИЙ
УНДЭСНИЙ
УНДЭСНИЙ

шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн шинжилгээний байгууллагад сонгон шалгаруулж ажиллуулж ирсэн түүхэн уламжлал нь Монгол Улс дахь эрх зүйн боловсрол олгож эхэлсэн үеэс эхлэлтэй юм. Профессор С.Жанцан 1960 онд МУИС-ийн бүрэлдэхүүнд Хуулийн салбар байгуулагдан ажилласнаар хууль зүйн сургалт судалгааны ажил явуулах, цаашид хууль зүйн шинжлэх ухааны хөгжих оюуны уурхай болсон гэж дүгнэжээ (С.Жанцан, 2005). Энэ үеэс хуулийн салбарт Захиргааны эрх зүйн хүрээнд “Цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагаа” (Ж.Долгорсүрэн, 2014), “Эрүүгийн эрх зүй”, “Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй”, “Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн эрх зүй” хичээлийг тусгай хөтөлбөрөөр зааж байсан бол криминологи хичээлийг хэдий үеэс зааж эхэлсэн талаар баримт байхгүй байна. Монгол Улсад 1974 онд БНМАУ-ын Прокурорын газрын дэргэд Гэмт явдлын шалтгаан нөхцөлийг судлах хүрээлэнг байгуулж, олон арван судалгаа хийж байсны дотор МУИС-ийн хуулийн салбарын эрдэмтэн судлаачид голлох хувийг эзэлж байснаас дүгнэхэд Криминологи хичээл ямар нэгэн төвшинд судлагдаж байсан байх боломжтой юм.

1992 оноос хувийн хэвшлийн их дээд сургууль байгуулахыг Үндсэн хуулиар зөвшөөрсөнтэй холбоотойгоор хууль зүйн их, дээд сургуулиуд байгуулагдаж эрх зүйч мэргэжил олгох сургалтын хөтөлбөрт “Криминологи”, “Цагдаагийн эрх зүй”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “Хоригдлыг нийгэмшүүлэх”, “Гэмт хэргийн ул мөртэй ажиллах” зэрэг хичээлийг сонгох, эсхүл цөөн цаг цагаар судалж байснаас гадна “Эрүүгийн эрх зүй”, “Эрүүгийн процессын эрх зүй” хичээлийг 3 багц цагаар заавал судлахаар тусгаж сургалт явуулдаг байсан нь хууль сахиулах салбарын хүний нөөцийг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байсан гэж үзэж болох юм.

МУИС болон бусад хувийн хэвшлийн их, дээд сургууль төгсөгчдөөс цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллах сонирхолтой төгсөгчийг сонгон авч хүний нөөц бүрдүүлэх явдал өнөөг хүртэл

түгээмэл байсаар байна. Тухайлбал, 2024 оны байдлаар цагдаагийн байгууллагын хүний нөөцийн 31.8 хувийг дотоод хэргийн их сургууль төгсөгчид, 68.2 хувийг иргэний их, дээд сургууль төгссөн хүмүүс бүрдүүлж байгаа бөгөөд үүнээс 48.9 хувь эрх зүйн боловсролтой байна. Харин Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн 20.8 хувийг дотоод хэргийн их сургуулийн төгсөгч, 79.2 хувийг бусад их дээд сургуулийн төгсөгч эзэлж байгаа бол үүнээс 20.7 хувь нь эрх зүйч мэргэжилтэй алба хаагч эзэлж байна (Комисс, 2024).

Мөн хууль зүйн их дээд сургуулийн эрх зүйн чиглэлийн магистрын сургалтын хөтөлбөрт хууль сахиулах салбарын алба хаагчид элсэн суралцаж “Криминологи”, “Цагдаагийн эрх зүй”, “Эрүүгийн эрх зүйн”, “Эрүүгийн процессын эрх зүй”-н чиглэлээр магистрын зэрэг хамгаалсан тохиолдол цөөнгүй байна. Тухайлбал, цагдаа судлалын чиглэлээр магистрын зэрэг хамгаалж буй судлаачдыг сургуулиар нь авч үзвэл, 49.1 хувь нь Дотоод хэргийн их сургуульд, 10.3 хувь нь Их засаг их сургууль, 10.3 хувь нь Билиг дээд сургууль, 7.6 хувь нь Монголын үндэсний их сургууль, 6.3 хувь нь МУИС-ийн Хууль Зүйн Сургуульд тус тус хамгаалагдсан байна (Гэмт явдалтай тэмцэх асуудал онол, 2017).

Монгол Улсад хууль сахиулах боловсрол олгоход чиглэсэн эрх зүйч мэргэжлээс ялгаа бүхий “Цагдаа судлал”, “Гэмт хэрэг судлал” гэсэн бие даасан сургалтын хөтөлбөр өнөөг хүртэл иргэний их, дээд сургуулиудад нэвтэрч сургалт, эрдэм шинжилгээний эргэлтэд ороогүй, хууль сахиулах боловсролыг эрх зүйн боловсролоос ялган хөгжүүлэх бодлого бүрэлдээгүй, түүнийг агуулга мөн чанарыг үнэлэх, хүлээн зөвшөөрөх хандлага сул байсаар байна.

5. Иргэний их, дээд сургуулийн “Гэмт хэрэг”, “Цагдаа судлал” хөтөлбөрийн онцлог, ач холбогдолд хийсэн дүн шинжилгээ

Хууль сахиулах боловсрол олгох чиглэлээр “Гэмт хэрэг судлал”, “Цагдаа судлал”-ын хөтөлбөр хэрэгжүүлдэг гадаадын зарим их дээд сургууль (хавсралтаас үзнэ үү) болон

төрийн мэдлийн хууль сахиулах сургуулийн хөтөлбөрийн агуулгад харьцуулан дүн шинжилгээ хийхэд дараах нийтлэг болон ялгаатай тал илэрч байна. Хөтөлбөрийг төрийн болон хувийн хэвшлийн сургуульд хэрэгжүүлж байгаагаас үл хамаарч хууль сахиулах боловсрол олгох, нийтийн хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах болон олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай онолын мэдлэг, ур чадвар, ёс зүйн төлөвшил олгоход чиглэгддэг ба иргэдийн итгэлийг хүлээж, эерэг харилцаа тогтоох зорилгод аль аль нь чиглэгддэг байна (Sherman, 1978).

Харин сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх процесст дараах ялгаа байна. Үүнд:

- Хөтөлбөрийн судлах зорилго: Иргэний их, дээд сургуулийн хөтөлбөрийн зорилго нь хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаа, бодлогын дүн шинжилгээ, гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлал болон хууль сахиулах байгууллагын захиргаа гэх мэт гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцооны талаар боловсрол олгоход чиглэгддэг. Эдгээр хөтөлбөрөөр төгсөгчдөд олон салбарт хөрвөн ажиллах чадвар олгоход чиглэдэг бөгөөд зөвхөн цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага төдийгүй хуульч, бодлогын судлаач, шинжээч болон хувийн аюулгүй байдлыг хангах албанд ажиллах боломжийг олгодог байна. Харин төрийн мэдлийн цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх сургуулийн хөтөлбөрийн зорилго нь зөвхөн хууль сахиулах салбарт ажиллах практик ур чадвар, бие бялдар, сэтгэл зүйн болон цагдаагийн ажлыг хийхэд шаардагдах тактик, хууль сахиулах процессыг хэрэгжүүлэх тусгай мэдлэг, чадвар бүхий хүний нөөц, офицерыг бэлтгэхэд чиглэгдэж, сургалтын хөтөлбөрийг төрөөс хянаж, зөвшөөрөл олгодог байна.

- Сургалтын агуулга: Иргэний их, дээд сургуулиудын хөтөлбөр нь онолын мэдлэг олгоход чиглэгдсэн гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцооны онол, гэмт хэрэг судлал, социологи, сэтгэл судлал, нийтийн захиргаа, хууль, ёс зүй, олон нийтэд

түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа, цагдаад итгэх олон нийтийн хандлага, цагдаа, хорих байгууллагын харьцуулсан судлал, шинжлэн магадлахуй зэрэг хичээлийг онол, судалгааны арга зүйд тулгуурлан судалдаг бөгөөд шинэ төрлийн гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх шинэ арга тактикийг нийгмийн үзэгдэлтэй холбон судалдаг байна. Тухайлбал, цахим гэмт хэрэг, форензик ярилцлага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны ёс зүй гэх мэт. Бие бялдрын чадвар олгох, галт зэвсгийн бүтэц, зүй тогтол болон тактикийн хичээлийг хууль сахиулах мэргэжлийн сургуультай харьцуулахад маш бага цагаар заадаг байна. Харин төрийн мэдлийн хууль сахиулах сургуулийн хөтөлбөр нь бие хамгаалах, үйл ажиллагааны тактик, галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх, цэргийн хэргийн мэдлэг олгох, удирдлагын шийдвэрийг гүйцэтгэх чадвар, зохиомол орчинд суурилсан дадлагын сургалт, тухайлбал, хэргийн газрын үзлэг, ул мөр бэхжүүлэх, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, жагсаал цуглаан, замын хөдөлгөөн зохицуулах, сэжигтэн, хохирогчтой ажиллах арга зүй, хууль зүйн мэдлэг, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны дараалал, олон нийттэй харилцах ур чадвар, хариу арга хэмжээний үеийн шийдвэр гаргалт гэсэн сургалт дийлэнх хувийг эзэлдэг байна.

- Хөтөлбөрт суралцах суралцагч, багш: Иргэний их, дээд сургуулийн хөтөлбөрт хууль сахиулах, улс төрч, бодлогын шинжээч болон судлаач, нийгмийн ажлын чиглэлээр ажиллах сонирхолтой иргэн, эсхүл дээд боловсролтой эзэмшсэн хэн ч элсэн суралцах боломжтой байдаг бол төрийн мэдлийн хууль сахиулах сургуульд ирээдүйд хууль сахиулах салбарын ажилтан болоход шаардагдах тусгай шалгуураар сонгогдсон суралцагч (сонсогч) болон карьераа дээшлүүлэх зорилгоор суралцаж байгаа албан тушаалтан суралцагч онцлогтой. Багшлах бүрэлдэхүүний хувьд иргэний их дээд сургуулиудад “гэмт хэрэг судлал”, “цагдаа судлал”-ын чиглэлийн онолын эрдэмтэн, судлаачид ихэвчлэн багшлах, эрдэм



МОНГОЛЫН ХУУЛЬ ЗӨРХӨӨ



Хууль сахиулах
боловсрол судлал

шинжилгээ судалгааны ажил хийдэг бол хууль сахиулах чиглэлтийн сургуульд практик туршлага бүхий багш, судлаачид ажилладаг байна.

- Сургалт явуулах арга зүй: Иргэний их, дээд сургуулиудад ихэвчлэн лекц, семинар, судалгааны төсөл, бүлгийн хэлэлцүүлэг, бичгийн даалгавар хэлбэртэй байдаг бол практик сургалтыг гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцооны байгууллага болох цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, хорих анги, албадан сургалтын төв, тэдгээрийн үйл ажиллагаатай танилцах, дадлага хийх хэлбэрээр явуулдаг байна. Харин төрийн мэдлийн хууль сахиулах сургуулиуд ихэвчлэн биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх болон хууль хэрэглээний чадвар олгох сургалтыг бага бүлэг, зохиомол орчин бүрдүүлэх, тохиолдол шинжлэх байдлаар явуулдаг. Онолын мэдлэг олгох сургалтыг сургалтын нийтлэг арга болох лекц, семинар, бие даалт гэх мэт иргэний их, дээд сургуульд ашигладаг нийтлэг аргаар явуулдаг ч харьцангуй бага цагийг зарцуулдаг байна. Суралцах хугацаандаа гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцооны байгууллагуудад дадлага хийж, практик ажилд оролцох, дэмжлэг үзүүлэх байдлаар ур чадвар сэтгэл зүйн бэлтгэлийг эзэмшдэг байна. Сургалтын орчны хувьд цэргийн баазтай төстэй өндөр зохион байгуулалт, дэг журам мөрдөгддөг харуул хамгаалалт бүхий сургалтын орчин бүрдүүлсэн хотхон (кемп)-д зохион байгуулдаг бөгөөд суралцагчид ихэвчлэн байрлаж суралцдаг байна.

- Суралцах хугацаа: Иргэний их, дээд сургуулийн бакалаврын боловсрол олгох хөтөлбөр 2-4 жил, магистр, докторын сургалтын хөтөлбөр 2-3 жилийн хугацаагаар суралцдаг. Түүнчлэн тус хөтөлбөрт өдөр, орой, эчнээ хэлбэрээр суралцах боломжтой бөгөөд цахим сургалтын хэлбэрээр суралцах хувилбарын санал болгодог. Харин төрийн мэдлийн хууль сахиулах сургуулиуд ихэвчлэн сургалтын төвшин, олгох чадвараасаа хамаарч хэдэн сараас 2 жил хүртэл мэргэшүүлэх сургалт, бакалаврын боловсрол олгох сургалт 4 жил, магистр,

докторын сургалтын хөтөлбөр 3-5 жилээр суралцах боломжтой. Хөтөлбөрүүд нь ихэвчлэн бүтэн цагаар өдрөөр суралцахыг шаардлага бөгөөд цахим болон сонголттой уян хатан байх боломж хязгаарлагдмал байдаг нь судалгаанаас харагдаж байна.

Хөдөлбөрийн нийтлэг болон ялгаатай байдлаас үзэхэд, иргэний их дээд сургуулиуд оюутнуудыг хууль сахиулах, аюулгүй байдал, судалгааны салбарт бэлтгэж, гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцооны талаар онол, арга зүйн гүнзгий мэдлэг олгоход чиглэдэг бол төрийн мэдлийн хууль сахиулах сургууль, академи нь практик ур чадвар, сахилга бат, хууль сахиулах үйл ажиллагааг алдаагүй хэрэгжүүлэх дадал, чадварт бэлтгэх сургалт явуулдаг онцлогтой болох нь дүгнэгдэж байна.

Харьцуулсан судалгаанаас үзэхэд иргэний их, дээд сургуульд “Гэмт хэрэг судлал”, “Цагдаа судлал”-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь дор дурдсан ач холбогдлыг илэрхийлдэг байна (Sherman L. W., 2019) (Weisburd, 2015) (Lum, 2017). Үүнд:

- Судалгаа, дүн шинжилгээний ажил хөгждөг: Хууль сахиулах салбарын үйл ажиллагаа, цаашид хэрэгжүүлбэл зохих арга хэмжээний талаар шинжлэх ухааны үндэслэл бүхий дүгнэлт, санал гаргах чадавх нэмэгддэг. Тухайлбал, цагдаа, хорих байгууллагын үйл ажиллагааны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх, хэрэгжүүлсэн арга хэмжээг үнэлэх, хууль сахиулах салбарын шинэчлэлийн талаар олон ургалч үзэл гарч, тэдгээрийг тойрсон үндэслэл бүхий хэлэлцүүлэг өрнөдөг бөгөөд шинэчлэлийн бодлогод тусгалаа олдог.

- Хууль сахиулах салбарын талаарх мэдлэг нэмэгддэг: Хөтөлбөрт цагдаагийн байгууллагын шинэчлэл, алба хаагчийн ёс зүй, цагдаагийн харьцуулсан судлал, хууль сахиулах байгууллагын орчин үеийн асуудал, олон нийтэд түшиглэсэн хууль сахиулах үйл ажиллагаа, хууль сахиулах ажиллагаанд хүний эрхийг хангах зэрэг хичээлүүд багтдаг. Энэ нь олон нийт хууль сахиулах салбарын үйл ажиллагааг ойлгож, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг.

- Хууль сахиулах салбарт шинэ соёл нэвтрүүлэхэд нөлөөлдөг: Хууль сахиулах салбар, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад манлайлах, олон улсын туршлага, шинэ хандлагыг нэвтрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Удирдлагын арга барил, байгууллагын соёл, стратеги төлөвлөлтийн талаар мэдлэг олгох замаар суралцагчдад шинэчлэлийг ойлгуулах, удирдах чадвартай болгодог.

- Хамтын ажиллагааны боломжийг бүрдүүлдэг: Их дээд сургуулиуд хууль сахиулах салбар, цагдаа, хорих байгууллага болон төрийн байгууллагуудтай байнга хамтран ажиллаж, цаг үеийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, шинэчлэлийн стратеги боловсруулахад дэмжлэг үзүүлдэг. Энэхүү хамтын ажиллагаанд дадлага хийх, хамтарсан судалгааны төсөл хэрэгжүүлэх, бодлого судалгаа боловсруулах зэрэг ажил багтаж болно.

- Олон нийтэд түшиглэсэн үйл ажиллагаа явуулах боломжийг нэмэгдүүлдэг: Хөтөлбөрт цагдаа, олон нийтийн харилцаа, нийтийн дэг журам сахиулахад олон нийтийн гүйцэтгэх үүрэг, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааг ойлгох, олон нийтийн дэмжлэг, түүний ач холбогдлыг нэмэгдүүлэх, олон нийтийн санаа бодлыг тандан судлахад тусалдаг.

- Бодлогын нөлөөлөл: Эдгээр хөтөлбөрийн төгсөгчид нь олон улс, бүс нутаг, үндэсний хэмжээний хууль сахиулах салбарын шинэчлэлийг хэрэгжүүлэх бодлого, хууль тогтоомжийг боловсруулах ажилд оролцох, шинэчлэлийн бодлогод нөлөө үзүүлэх, харилцан туршлага солилцох ажилд чухал үүрэг гүйцэтгэдэг. Өөрчлөлтөд дасан зохицох чадвар эзэмшдэг: Их сургуулийн хөтөлбөрөөр боловсрол эзэмшсэн хууль сахиулах салбарын алба хаагчид хууль сахиулах үйл ажиллагаа болон нийгмийн хүлээлтэд нийцүүлэн гарсан өөрчлөлтөд дасан зохицоход илүү сайн бэлтгэгдсэн байдаг нь шинэчлэлийг хүлээн авах, өөрчлөлтөд илүү үр дүнтэй, хөрвөх чадвартай ажиллах боломжийг нэмэгдүүлдэг.

6. Монгол Улсад иргэний их, дээд сургуулиудад “Гэмт хэрэг судлал”,

“Цагдаа судлал” хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломж, хэрэгцээ

Дээд боловсролын тухай хуульд “Цэрэг цагдаагийн мэргэжлийн чиглэлийн сургалтын үйл ажиллагааг Боловсролын ерөнхий хуулийн 3.1.18-д заасан төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллага эрхэлнэ” (Дээд боловсролын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг, 2023), Боловсролын ерөнхий хуулийн дээрх заалтад “Цэрэг, цагдаагийн дээд боловсролын сургалтын байгууллага” гэж зэвсэгт хүчин, тагнуул, хил хамгаалах, цагдаа, онцгой байдлын мэргэжлийн чиглэлээр сургалт эрхэлдэг хуулийн этгээдийг” ойлгоно (Энэ зохицуулалтад хууль сахиулах салбарын бүрэлдэхүүн хэсэг болсон шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн шинжилгээний байгууллагыг орхигдуулсан байгааг залруулах шаардлагатай.) гэж заасан.

Үүнтэй холбоотойгоор “гэмт хэрэг судлал”, “Цагдаа судлал” гэсэн хууль сахиулахын боловсрол олгоход чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх тусгай зөвшөөрлийг иргэний их, дээд сургуульд олгодоггүй байна. Харин Их засаг олон улсын их сургуульд “Хувийн аюулгүй байдал” гэсэн хөтөлбөр хэрэгжүүлж байгаа ба энэ хөтөлбөрийг шүүмжилж хязгаарлахаас илүү сургалтын агуулга, зорилгыг оновчтой болгох нь хууль сахиулах боловсролыг дэмжих ач холбогдолтой. Тухайлбал, сургалтын хөтөлбөрт аюулгүй байдал, хувийн аюулгүй байдлын онол, хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах стратеги, гадаад орны туршлага, нийтийн хэв журам сахиулах ажилд дэмжлэг үзүүлэх, аюулгүй байдлыг хангах техник, технологийн шийдэл, тэдгээрийг ашиглах чадварт сургахад чиглэсэн хичээлийг суулгах ёстой. Эсрэгээрээ дүрэмт хувцас хэрэглэх, цэргийн зохион байгуулалт бүхий хэв шинжийг арилгаж, бие бялдар, тусгай хэрэгсэл хэрэглэх чадварыг бие даан сургахад анхаарах шаардлагатай.

Олон улсын чиг хандлагын дагуу хууль сахиулахын боловсрол гэсэн ойлголтыг өргөн хүрээнд тодорхойлж, тухайн салбарын шинжлэх ухааны мэдлэг,



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗАСАГ



Хууль сахиулах үйлчилгээ

чадавхыг хөгжүүлэх зорилгоор иргэний их, дээд сургуулиудад “Гэмт хэрэг судлал” “Цагдаа судлал” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага байгааг дараах үндэслэлээр тайлбарлаж болохоор байна.


А) Хууль сахиулах мэргэжлээр суралцах сонирхол бүхий иргэдийн тоо нэмэгдэж байна.

Хууль сахиулагчийг бэлтгэх чиг үүрэг бүхий Дотоод хэргийн их сургуулийн элсэлтийн судалгаанаас үзэхэд хууль сахиулах, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон шүүхийн шинжилгээний байгууллагад ажиллах сонирхолтой хүмүүсийн тоо жилээс жилд нэмэгдэх хандлагатай байгаа ч тэдгээрийн 6-20 орчим хувь нь тус сургуульд элсэн суралцаж байна.


Элсэхээр хүсэлт гаргасан иргэдийн дунд эмэгтэйчүүдийн тоо маш өндөр

үзүүлэлттэй байгааг нь сонирхолтой юм. Тухайлбал, Дотоод хэргийн их сургуулийн 2024 оны 08 дугаар сарын 22-ний өдрийн П-03/1222 дугаар албан бичигт дурдаснаар 2022 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хөтөлбөрт элсэн суралцах хүсэл гаргагчдын 379 буюу 84 хувь, шинжлэн магадлахуйн хөтөлбөрт элсэн суралцах гаргагчдын 458 буюу 93.8 хувь, 2023 онд цагдаагийн хөтөлбөрт элсэхээр хүсэлт гаргагчдын 817 буюу 45 хувийг тус тус эзэлж байсан бол энэ үзүүлэлт 2024 онд Цагдаагийн хөтөлбөрт 51.6, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хөтөлбөрт 91.2, шинжлэн магадлахуйн хөтөлбөрт 69.1 хувийг тус тус эзэлж байна. Хүсэлт гаргасан эмэгтэйчүүдээс цагдаагийн хөтөлбөрт 4.7 хувь, шүүхийн шийдвэрийн хөтөлбөрт 5.2 хувь, шинжлэн магадлахуйн хөтөлбөрт 5.1 хувь нь элссэн суралцаж байна.


Цагдаагийн алба хаагч бэлтгэх хөтөлбөр



Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба хаагч бэлтгэх хөтөлбөр



Шинжлэн магадлахуйн хөтөлбөрт



Дээрх статистикаас үзэхэд, хууль сахиулах чиглэлээр суралцах сонирхолтой иргэдийн 80-90 орчим хувь нь хүссэн мэргэжлээр элсэн суралцаж чаддаггүй байна. Элсэж чадаагүй иргэд бусад их, дээд сургуулийн эрх зүй болон бусад хөтөлбөрөөр суралцдаг, эсхүл дараа жил дахин элсэх сонгон шалгаруулалтад оролцдог байна. Дотоод хэргийн их сургуульд элсэн суралцах сонирхол иргэдийн дунд нэмэгдэж байгаа нь хууль сахиулах салбарын ажилтан болох хүсэл эрмэлзэл, суралцах хугацааны төлбөрийг төрөөс бүхэлд нь хариуцдаг, төгссөний дараа ажлын байраар 100 хувь хангагддаг зэрэг хүчин зүйлтэй холбон тайлбарлаж болно.

Хүний эрхийн Үндэсний Комисст (2024) Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас ирүүлсэн хүний нөөцийн мэдээллээс харахад цагдаагийн байгууллагын хүний нөөцийн 68.2 хувийг иргэний их, дээд сургууль төгссөн, үүнээс 48.9 хувь эрх зүйн боловсролтой, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн 79.2 хувийг иргэний их дээд сургууль төгссөн, үүнээс 20.7 хувь нь эрх зүйн боловсролтой алба хаагч тус тус эзэлж байна. Цагдаагийн байгууллагын хэмжээнд 551 албан тушаал /ажлын байр/ батлагдан мөрдөж байгаагаас ажлын байрны тодорхойлолтод 438 буюу 79 хувьд нь эрх зүйч мэргэжилтэй байх шаардлага тавьсан хэдий ч Дотоод хэргийн их сургуулийн төгсөгчид “эрх зүйч” мэргэжил олгохгүй

байх талаар гарсан Боловсрол шинжлэх ухааны сайдын тушаалтай нийцүүлэн Цагдаагийн ерөнхий газраас ажлын байрны тодорхойлолтдоо өөрчлөлт оруулж “аюулгүй байдал, цагдаа судлал” гэсэн мэргэжлийн чиглэлийг нэмж тусгаж байна (БСШУ-ны сайдын А/343 дугаар тушаал, 2022).

Цагдаагийн байгууллага олон жилийн турш гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий албан тушаалтныг эрх зүйч мэргэжилтэй байхаар шалгуур тавьж байгаа хандлагыг олон улсын жишигт нийцүүлэн өөрчлөх шаардлага зүй ёсоор тулгарч байна. Түүнчлэн Цагдаагийн албаны тухай хуульд ч энэ хандлага хадгалагдсан хэвээр байна. Тухайлбал, Цагдаагийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Цагдаагийн төв байгууллагын даргаар цагдаагийн албанд 20-оос доошгүй жил ажилласан, эрх зүйч мэргэжилтэй...”, мөн зүйлийн 20.4 дэх хэсэгт “...тэргүүн дэд дарга, дэд даргаар цагдаагийн албанд 15-аас доошгүй жил ажилласан, эрх зүйч мэргэжилтэй...” байхаар заасан. Гэтэл Дотоод хэргийн их сургууль төгсөгчдөд “эрх зүйч” мэргэжил олгохгүй байх шийдвэр хэрэгжиж эхлээд бараг 10 жил болжээ (БСШУС-ын сайдын 178 дугаар тушаалын хавсралт, 2014).

Эрх зүйч болон бусад мэргэжлээр төгссөн иргэнд хууль сахиулах боловсрол, мэргэжлийн чиг баримжааг Дотоод хэргийн их сургуулийн офицер бэлтгэх,





Хууль сахиулах чиглэлээр судлаачид

давтан сургалт болон Цагдаагийн ерөнхий газрын Сургалтын төвөөр дамжуулан олгож байна. Учир нь эрх зүйч бэлтгэж байгаа хууль зүйн их, дээд сургуульд хууль сахиулах салбарт ажиллахад шаардлагатай мэдлэг олгох гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо, цагдаа, шүүхийн шийдвэр, шүүхийн шинжилгээний байгууллагын онцлог, хөгжлийн чиг хандлага, харьцуулсан судалгаа, цагдаа олон нийтийн хамтын ажиллагаа, гэмт хэргийн үл мөртэй ажиллах, гэмт хэргийн статистик, сэтгэл зүй, криминологи гэх мэт хичээл сургалтын хөтөлбөрт бараг тусдаггүй, эсхүл сонгон судлах байдлаар явагдаж байгаа юм.

Хууль сахиулах боловсрол нь эрх зүйн боловсролоос ялгаатай бөгөөд илүү практикт суурилсан хууль хэрэглээний чадвар суулгахад чиглэгдсэн байдаг онцлогтой. Тиймээс хууль сахиулагчдад хууль зүйн мэдлэгтэй байх, түүнийг хэрэгжүүлэх чадвар олгох сургалтыг хууль сахиулах боловсролын хөтөлбөрт заавал тусгахыг шаарддаг бөгөөд хуульч гэдэг агуулгаар тус сургалтыг явуулдаггүй байна. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Боловсрол шинжлэх ухааны сайдын тушаалаар эрх зүй, хууль сахиулах (аюулгүй байдал) боловсролын ялгааг нарийвчлан тодорхойлж мэргэжлийн чиглэлийг тогтоожээ. Үүнээс харахад БСШУС-ын сайдын 2014 оны 178 дугаар тушаалаар Дотоод хэргийн их сургуулийн хэрэгжүүлдэг хөтөлбөрүүдийг “хууль сахиулах ажил” гэж нэрлэж эхэлсэн бөгөөд үндсэндээ энэ үеэс эрх зүйч мэргэжил олгохыг зогсоосон байна. Өнөөгийн байдлаар Дотоод хэргийн их сургуулийн хууль сахиулах, аюулгүй байдлын чиглэлийн хөтөлбөрөөр төгсөгчдийг хуульчийн сонгон шалгаруулалтад оролцуулахгүй, цаашилбал, шүүгч, прокурор, өмгөөлөгч болон бусад хуульчаар ажиллах боломжийг хязгаарласан, Дотоод хэргийн их сургуулийг түшиглэсэн докторын зэрэг олгох чиглэлийг “Хууль сахиулахуй, дотоод хэрэг” гэсэн чиглэлээр олгож байгаа зэрэг нь эрх зүй болон хууль сахиулах боловсролын агуулга ялгаатай гэдгийг харуулсан бодлого юм.

Хууль сахиулах чиглэлээр гадаад, дотоодод боловсрол эзэмшсэн, эрдмийн зэрэг хамгаалсан мэргэшсэн судлаачид хууль зүйн их, дээд сургуульд багшлах явдал нэмэгдсэн нь энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүний нөөц бүрдэж байгааг харуулах юм. Өнөөдрийн байдлаар Монгол Улсын Их сургууль, Шихихутуг их сургууль, Улаанбаатар олон улсын их сургууль, Отгонтэнгэр их сургууль, Идэр их сургууль, Орхон их сургуульд энэ чиглэлийн мэргэшсэн эрдэмтэн судлаачид цөөнгүй ажиллаж байна.

Хууль сахиулах салбарт ажиллах сонирхол бүхий иргэдэд зориулсан “гэмт хэрэг судлал”, “Цагдаа судлал”-ын бакалавр, магистр, докторын сургалтын хөтөлбөрийг иргэний их, дээд сургуульд хэрэгжүүлэх замаар хууль сахиулах, аюулгүй байдал, эрдэм шинжилгээний салбарт ажиллах хүний нөөцийг бэлтгэх, зохих шалгуур хангасан иргэдийг тусгай албанд сонгон шалгаруулж авах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай.

Б) Хууль сахиулах салбарын онолын мэдлэг, судалгааны чадавхыг нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулах:

Хууль сахиулах салбарын судалгаа эрдэм шинжилгээний ажлыг шинжлэх ухааны арга зүйд тулгуурлан хөгжүүлэх, гэмт явдал, цагдаа судлалын онол, харьцуулсан судалгаа төдийлөн хөгжөөгүй нь хэд хэдэн судалгаагаар дүгнэгдсэн. Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгээс “Монгол Улс дахь цагдаа судлалын төлөв байдал” суурь судалгааны ажилд 1967-2015 оны хооронд Монгол Улсын хэмжээнд цагдаа судлалын чиглэлээр бичигдсэн 5 хэлбэрийн 609 судалгааны бүтээл тухайлбал, 1/ ном, сурах бичиг, 2/ эрдмийн зэрэг горилсон бүтээл (доктор), 3/ магистрын дипломын ажил, 4/ илтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, 5/ суурь болон хэрэглээний судалгааны ажлуудын агуулга, судалгааны арга зүйд дүн шинжилгээ хийсэн (Б.Энхболд, 2017). Судалгааны дүнгээр, байгууллагын эрх зүйн байдал, гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зэрэг гадагш чиглэсэн судалгааны ажил нийт

бүтээлийн 30 гаруй хувийг эзэлж байгаа бол цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны мөн чанарыг нээн илрүүлэх, гадаад орны сайн туршлагыг нэвтрүүлэхэд чиглэгдсэн цагдаагийн үйл ажиллагааны онол, харьцуулсан судлал, цагдаа олон нийтийн хамтын ажиллагаа, хүний нөөц зэрэг сэдвүүд харьцангуй бага судлагдсан гэж дүгнэжээ.

Цагдаа судлалын чиглэлээр хийгдсэн судалгааны ажлуудад нийгмийн шинжлэх ухааны салбарт түгээмэл хэрэглэгддэг баримт бичигт дүн шинжилгээ хийх, санал асуулга авах, хууль тогтоомжид дүгнэлт хийх, фокус бүлгийн ярилцлага хийх зэрэг аргуудыг түгээмэл хэрэглэж байгаа бол нийгмийн шинжлэх ухааны онолын хийсвэр ойлголт, нэр томьёонуудад хэмжилт хийх, үндэслэл бүхий дүгнэлт гаргахад ач холбогдол бүхий математик, статистикийн аргачлал, дүн шинжилгээ хийх аргыг ашиглахгүй байгаа нь судалгааны үр дүнг олон улсын хэмжээнд танилцуулах, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргахад хүндрэл учруулж байна гэж дүгнэсэн. Тус хүрээлэнгээс хийсэн “Эрдэм шинжилгээний өгүүлэл бичихэд анхаарах асуудал” судалгааны дүгнэлтэд “Судлаачдын нийтлүүлсэн өгүүлэл нь онолын үндэслэл, судалгааны арга зүйд тулгуурлаагүй, зөвхөн юмс үзэгдлийг тодорхойлон тайлбарласан танин мэдэхүйн шинжтэй байна” гэж дүгнээд олон улсын түвшинд эрдэм шинжилгээний бүтээлд тавигдах жишиг шаардлага, судалгааны арга зүйг хөгжүүлэх шаардлага тулгарч байгааг сануулжээ (Б.Энхболд С., 2018).

Дотоод хэргийн их сургуулийн зүгээс хууль сахиулах боловсролын асуудлыг өргөн хүрээнд дүгнэж, цаашид авах арга хэмжээний талаар тодорхой санал дүгнэлт дэвшүүлж байсан ба тодорхой үр дүн гарч байгаа ч цаашид эрчимжүүлэх шаардлага байна. Тухайлбал, 2005 оноос ДХИС-ийн бүрэлдэхүүнд Эрдэм шинжилгээний хүрээлэн байгуулж, “Цагдаа судлал”, “Гэмт явдал судлал”, “Шүүхийн шийдвэр судлал”, “Шинжлэн магадлахуйн төв”, “Хууль сахиулахуйн боловсрол судлал”-ын төв”, Холбогдох профессоровын судалгааны багийг байгуулж сургалт судалгааны ажил хийсний

үр дүнд 2017 онд “Цагдаа судлал”-ын чиглэлээр олон улсын хянан магадлагаа бүхий сэтгүүлд эрдэм шинжилгээний анхны бүтээл нийтлэгдсэн (Enkhbold.B, 2017), Цагдаагийн алба хаагчийг бэлтгэх сургалтын тогтолцоо (Э.Дашгаадан, 2023), Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зүй (Б.Хулан, 2023), Цагдаагийн байгууллагаас олон нийттэй харилцах асуудал (Б.Эрдэнэбилэг, 2023) зэрэг шинэ судалгааны чиглэлүүд ахиц гарч байна. Гэсэн хэдий ч “Хууль сахиулах”, “Цагдаагийн судлал”-ын чиглэлийн судалгааны ажлын үр дүн олон улсад нийтлэгдэх тохиолдолд маш цөөн хэвээр байна. Харин бусад их дээд сургуулийн профессор, эрдэмтэн судлаачдын зүгээс энэ чиглэлийн судалгаа, шинжилгээний ажилд харьцангуй бага анхаарч байна.

“Цагдаа судлал”, “Гэмт хэрэг судлал”, “Гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо”-ны талаарх онол, арга зүйг хөгжүүлэх, шинжлэх ухааны мэтгэлцээнийг бий болгох, харилцан туршлага солилцоход энэхүү хөтөлбөрийг иргэний их, дээд сургуулиудад хэрэгжүүлэхийн ач холбогдол өндөр юм.

В) Хууль сахиулах салбарын шинэчлэл, хэлэлцүүлгийн явцад хөндлөнгийн үнэлгээ хийх хараат бус судлаачдын оролцоог хангах:

Хууль сахиулах салбар, ялангуяа цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шинэчлэлийн асуудлыг сүүлийн 30 гаруй жил хэлэлцэж зохих өөрчлөлт гарч байгаа ч Улсын их хурлын сонгууль, Засгийн газрыг шинээр байгуулах, эсхүл олон нийтийн анхаарал татсан асуудал үүссэний дараа нийгэмд шинэчлэлийн талаар хүчтэй яригддаг ч онол, судалгааны үндэслэлтэй хариулт өгөх, дүгнэлт, санал гаргах хөндлөнгийн судлаач, шинжээчдийн оролцоо хангалтгүй байгаа юм. Тухайлбал, 2008 оноос цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, гэрч хохирогчийг хамгаалах тогтолцоо, хууль сахиулах салбарын хүний нөөцийг бэлтгэх асуудлын талаар хэлэлцэж байсан ч өнөөг хүртэл тогтолцооны шинжтэй томоохон судалгаа, дүгнэлтүүд ховорхон байна.





ᠬᠤᠠᠭᠠᠳᠠ ᠰᠤᠳᠠᠯᠠ

Нээлттэй нийгэм форум төрийн бус байгууллага, Монголын Эмнести интернэшнл олон улсын байгууллагын зүгээс цагдаа, хууль сахиулах салбарын үйл ажиллагааг хүний эрхэд нийцүүлэн боловсронгуй болгоход чиглэсэн судалгаа, дүн шинжилгээний ажлыг хөндлөнгийн судлаачдаар гүйцэтгүүлж ирсэн нь энэ салбарын үйл ажиллагаа, хууль тогтоомжийг боловсронгуй болгоход чухал үүрэг гүйцэтгэж ирснийг дурдах нь зүйтэй. Тухайлбал, цагдаагийн ажил дүгнэх үзүүлэлт, олон нийтийн цагдаагийн үйл ажиллагаа, ил тод байдал, цагдаагийн хэрэглэгчийн үнэлгээ, жагсаал цуглааны үеийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, цагдаагийн хууль тогтоомжийг үнэлэх, зан үйлд нөлөөлөх сургалт явуулах, хорих ял эдлүүлэх үйл ажиллагаа, нийгэмшүүлэх асуудал гэх зэрэг судалгааны ажлыг дурдаж болно (<https://forum.mn/>). Мөн төрийн бус байгууллагын зүгээс энэ чиглэлийн судалгаа, дүгнэлтүүдийг хийдэг боловч тэдгээр нь тогтвортой бус, санхүүжилтээс шалтгаалан үр дүндээ хүрэхгүй байх тохиолдол цөөнгүй байна. Дотоод хэргийн их сургуулийн судлаачдын дүгнэлт, саналыг практик үйл ажиллагааг сайжруулахад ашиглаж байгаа ч Засгийн газрын харьяа байгууллага гэсэн агуулгаар улс төрийн нөлөөлөлтэй, хөндлөнгийн бус гэж үзэх хандлага ч байгааг анхаарах нь зүйтэй.

Хууль сахиулах боловсролын тогтолцоог өргөжүүлж “Гэмт хэрэг судлал”, “Цагдаа судлал” хөтөлбөрийг иргэний их, дээд сургуульд хэрэгжүүлснээр шууд үр дүн гарахгүй ч ирээдүйд төгсөгчдөөс тус салбарын мэргэшсэн хараат бус хөндлөнгийн судлаач, шинжээчид төрөн гарах, хууль сахиулах салбарын шинэчлэл, бодлогд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх боломжтой юм. Гадаад улсын туршлагаас үзэхэд хууль сахиулах салбарын шинэчлэл, инновацад хөндлөнгийн шинжээч, профессор, судлаачдын оролцоо ихээхэн нөлөө үзүүлдэг байна.

Г) Олон нийтэд түшиглэсэн хууль сахиулах үйл ажиллагаа хөгжүүлэх, олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх:

Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагааны стратеги нь цагдаа болон олон нийт хамтарч гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд хамтран ажиллах, асуудал шийдвэрлэх зөөлөн чадварт суурилсан хандлага юм. Уг стратегийн зорилго нь гэмт хэргийг буруулж, цагдаа олон нийтийн хамтын ажиллагааг сайжруулах, цагдаад итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэдэг (C Gill, 2014). Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой нийт өргөдөл, гомдлын 22.6 хувийг цагдаагийн алба хаагчийн харьцааны соёл, ёс зүй зөрчсөн талаар байгаа бол монголчуудын цагдаад итгэх хандлага “дунд зэрэг” гэсэн дүгнэлт гарсан байна (Б.Энхболд, 2018). Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн алба хаагч бэлтгэх сургалтын хөтөлбөрт “Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа”, “Цагдаагийн алба хаагчийн ёс зүй” гэсэн хичээлүүд туссан ч харьцангуй цөөн цагаар орж байна.

Олон нийтэд түшиглэсэн хууль сахиулах үйл ажиллагаа нь өргөн хүрээтэй ойлголт бөгөөд манай улсад зөвхөн “олон нийтийн цагдаа” гэсэн агуулгаар ойлгох нь түгээмэл байна. Олон нийтэд түшиглэсэн хууль сахиулах ажиллагааны хамгийн үр нөлөөтэй, хүчтэй механизм бол цагдаа, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаа, мөн чанарын талаар аль болох олон хүнийг гүнзгий мэдлэгтэй болгож хамтран ажиллах сэдэл төрүүлэх явдал юм. Ингэснээр Үл ойлголцол, ташаа мэдээллээс үүдэлтэй зөрчлийг бууруулахад тусалдаг.

Судалгаанаас үзэхэд иргэний их, дээд сургуулийн “Гэмт хэрэг судлал”, “Цагдаа судлал” хөтөлбөрийн агуулгад “Цагдаа олон нийтийн хамтын ажиллагаа”, “Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа”, “Цагдаад итгэх олон нийтийн хандлага”, “Хэвлэл мэдээлэлтэй харилцах”, “Асуудлыг зөөлөн аргаар шийдвэрлэх арга зүй”, “Харьцуулсан цагдаа судлал” гэх мэт хичээлийг үндсэн хичээл болгон судалж байна. Эдгээр сургалтаар олж авсан мэдлэг хандлага нь олон нийтэд түшиглэсэн

цагдаагийн үйл ажиллагааг хөгжүүлж, цагдаад итгэх олон нийтийн хандлагыг хөгжүүлдэг байна.

Дүгнэлт

1.Хууль сахиулах боловсролыг өргөн болон явцуу утгаар тодорхойлж хөгжүүлэх боломжтой. Өргөн утгаар авч үзвэл, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах, иргэдийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн шинжлэх ухааны мэдлэг бүтээх, хэрэглээнд нэвтрүүлэх, дадал, чадвар олгох цогц ойлголт. Явцуу утгаар авч үзвэл, хууль сахиулах салбар тухайлбал, цагдаагийн алба хаагч, мөрдөгч, шинжээч, ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэгч болон гэмт хэрэгтэй тэмцэх бусад салбарын хаагчдыг бэлтгэхэд чиглэгдсэн шинжлэх ухааны мэдлэг олгох, сургах үйл явц гэж үзэх боломжтой.

2.Хууль сахиулах боловсролын түүхэн хөгжлөөс үзэхэд хууль сахиулах дээд боловсрол олгох сургалтыг 1) Ихэвчлэн иргэний их, дээд сургууль хэрэгжүүлдэг АНУ-ын загвар, 2) Иргэний их, дээд сургууль болон төрийн мэдлийн цэргийн зохион байгуулалт бүхий сургууль хэрэгжүүлдэг холимог хэлбэрийн Европ-Азийн загвар, 3) Төрийн мэдлийн цэргийн зохион байгуулалт бүхий сургууль хэрэгжүүлдэг ОХУ, БНХАУ-ын загвар гэсэн гурван тогтолцоо бүрдсэн бөгөөд загвар бүр өөрийн давуу болон сул талтай байна. Монгол Улсын хувьд хууль сахиулах боловсрол олгох тогтолцооны өнөөгийн байдал нь гурав дахь буюу сүүлийн загвартай илүү төстэй байна.

3.Монгол Улсын Дотоод хэргийн их сургууль нь цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн шинжилгээний байгууллагын алба хаагчдыг бакалавр, магистр, докторын зэрэгтэй бэлтгэх сургалтыг олон улсын жишигт нийцсэн хөтөлбөр, орчин үеийн сургалтын анги танхим, номын сан, спорт цогцолбор, сургалт-дадлагын орчинд хэрэгжүүлж байгаа Монгол Улсын ууган сургуулийн нэг болжээ. Тус сургуулийн цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон шинжлэн магадлахуйн хөтөлбөрт элсэн суралцах хүсэлт гаргагчдын тоо жилээс

жилд нэмэгдэж байгаа ч зөвхөн 6-20 орчим хувь нь элсэн суралцдаг бол төгсөгчд 100 хувь ажлын байраар хангагддаг байна. Энэ нөхцөл байдалтай холбоотойгоор бусад их дээд сургууль төгсөгчдөөс цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн 65 орчим бүрдүүлж байна.

4.Хууль сахиулах боловсрол олгох хөтөлбөрийг төрийн мэдлийн хууль сахиулах сургууль олгохоос гадна иргэний их, дээд сургуулиудад хэрэгжүүлэх замаар онол, практикийн нэгдлийг хангах, хууль сахиулах салбарыг хөгжүүлэх, хүний нөөцийг бүрдүүлдэг орчин үеийн чиг хандлага зонхилж байна. Монгол Улсад хууль сахиулах боловсрол олгоход чиглэсэн эрх зүйч мэргэжлээс ялгаа бүхий “Цагдаа судлал”, “Гэмт хэрэг судлал” гэсэн бакалавр, магистр, докторын сургалтын хөтөлбөрийг иргэний их, дээд сургуульд хэрэгжүүлэх замаар хүний нөөцийг бүрдүүлэх, зохих шалгуур хангасан иргэдийг тусгай албанд сонгон шалгаруулж авах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай.

5.Иргэний их, дээд сургуулиудад хэрэгжүүлж буй хөтөлбөрийн нийтлэг болон ялгаатай байдлаас үзэхэд, иргэний их дээд сургуулиуд оюутнуудыг хууль сахиулах, аюулгүй байдал, судалгааны салбарт бэлтгэж, гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцооны талаар онол, арга зүйн гүнзгий мэдлэг олгоход чиглэдэг бол төрийн мэдлийн хууль сахиулах сургууль, академи нь практик ур чадвар, сахилга бат, хууль сахиулах үйл ажиллагааг алдаагүй хэрэгжүүлэх дадал, чадварт бэлтгэх сургалт явуулдаг онцлогтой болох нь дүгнэгдэж байна.

6.Иргэний их, дээд сургуульд “Гэмт хэрэг судлал”, “Цагдаа судлал”-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь хууль сахиулах салбарын судалгаа, дүн шинжилгээний ажлыг хөгжүүлэх, салбарын мэдлэг хандлага, манлайллыг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх, олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх, бодлогын нөлөөлөл үзүүлэх, өөрчлөлтөд дасан зохицох чадвар зэрэг ур чадварт бэлтгэдэг байна.



Санал

1. Дээд боловсролын тухай хуульд заасан “Цэрэг, цагдаагийн мэргэжлийн чиглэлийн сургалтын үйл ажиллагааг цэрэг, цагдаагийн дээд боловсролын сургалтын байгууллага” эрхэлнэ” гэсэн зохицуулалтыг хууль сахиулах боловсролын өргөн агуулгад нийцүүлэн өөрчлөх. Энэ агуулгад шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн шинжилгээний байгууллагыг оруулж томьёолох.

2. Иргэний их, дээд сургуульд хууль сахиулахын боловсрол олгоход чиглэсэн “Гэмт хэрэг судлал”, “Цагдаа судлал”, “гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо ба хууль сахиулах ажил” гэх мэт хөтөлбөрөөр бакалавр, магистр, докторын сургалт явуулах боломжийг нээх;

3. Дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвшөөрөл олгосон иргэний их, дээд сургуулиудад дүрэмт хувцас хэрэглэх, цэргийн зохион байгуулалт бүхий сургалт, бэлтгэл хийх, тусгай хэрэгсэл ашиглах гэх мэтээр цэрэг, хууль сахиулах чиглэлийн мэргэжлийн сургуулийн хэв шинжийг дурайх, өрсөлдөхийг хязгаарлах, зөвхөн бие даалт хэлбэрээр зохион явуулах зохицуулалт хийх.

4. Хууль сахиулах боловсролыг эрх зүйн боловсролын мэргэжлийн чиглэлээс ялгаж, бие даан хөгжүүлэх хандлагыг төлөвшүүлэх,

5. Дотоод хэргийн их сургуулийн хууль сахиулах боловсрол олгож байгаа цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэл, шинжлэн магадлахуйн хөтөлбөрөөр төгсөгчдийн мэргэжлийн ур чадварын төвшинд тогтмол үнэлгээ хийх аргачлалыг нэвтрүүлэх (галт зэвсэг, бие хамгаалах, хууль хэрэгжүүлэх, стандарт мөрдөх гэх мэт),

Ашигласан материалын жагсаалт

1. Andrew Maile. (2010). Research Fellow et al. “History, Police Education in England and Wales, and the Limited Role of Professional Ethics”.

2. David L. Carter and Allen D. Sapp. (1990). The evolution of higher education in law enforcement: Preliminary findings from a national study.

3. Bradley D. Edwards. (2019). Perceived Value of Higher Education among Police Officers: Comparing County and Municipal Officers. *Journal of Criminal justice education*. Volume 30: 606-620.

4. Garner, R. (1999). College-educated cops: Is the time now? Yes. In J. D. Sewell (Ed.), *Controversial issues in policing*. Boston, MA: Allyn and Bacon, 88-102.

5. Carlan, P. & Lewis, J. (2009). Professionalism in Policing: Assessing the Professionalization Movement. *Professional Issues in Criminal Justice*, 4, 39-57.

6. Paoline, E. A., III, & Terrill, W. (2007). Police education, experience, and the use of force. *Criminal Justice and Behavior*, 34: 179-196.

7. James E. Hawdon Donna A. (2021). Sedgwick in Policing: Do Increased Education Requirements Improve Police Performance and Procedural Justice? Virginia Polytechnic Institute and State University.

8. McCracken, Donal P. (1991). "The Irish in South Africa – The Police, A Case Study (Part 20)". *Irish Times*. Retrieved 8 August 2009.

9. Lyman, J. L (1964). "The Metropolitan Police Act of 1829: An Analysis of Certain Events Influencing the Passage and Character of the Metropolitan Police Act in England". *Journal of Criminal Law, Criminology, and Police Science*. 55 (1): 141–154 – via JSTOR.

10. Berman, Jay Stuart. (1987). *Police administration and progressive reform: Theodore Roosevelt as police commissioner of New York*.

11. Marion, N. (1998). Police academy training: Are we teaching recruits what they need to know? *Policing: An International Journal of Police Strategies and Management*, 21(1), 54-79.

12. Bowlby, Chris. (1986). "Blutmai 1929: Police, Parties and Proletarians in a Berlin Confrontation". *The Historical Journal*. 29 (1): 137–158.

13. Jacek Dworzecki. National Police Academy as a leading component of the police education system in France”.

14. Go, Julian. (2020). "The Imperial Origins of American Policing:



Militarization and Imperial Feedback in the Early 20th Century" *American Journal of Sociology* 125, (5).

15. Thomas Whetstone, George L.Kelling "English and American policing in the late 19th century".

16. Oliver, W. (2006). *The Fourth Era of Policing: Homeland Security. International Review of Law Computers & Technology*. 20: 49-62.

17. William G. O'Neill. (2005). *"Police reform in post-conflict societies: what we know and what we still need to know"*. International Peace Academy.

18. Sherman, L. W. (1978). *The quality of police education. National Advisory Commission on Higher Education for Police Officers*. San Francisco, CA: Jossey-Bass

19. Lawrence W. Sherman. (2019). (University of Cambridge, UK). *"Education in Evidence-Based Policing: The Global Challenge"*.

20. David Weisburd. (2015). (George Mason University, USA). *"Reforming Police Education: Evidence-Based Policing as a Core Element"*

21. Cynthia Lum. (2017). (University of Queensland, Australia), *Evidence-Based Policing: Translating Research into Practice"*.

22. Enkhbold Batzeveg. (2017) *"Confidence in the Police among Mongolian Immigrants in Korean and Native Mongolians*

in the home country: A Comparative Test of Conceptual Models" *International Journal of Law, Crime and Justice*". №3 (50).

23. C Gill, D Weisburd, CW Telep, Z Vitter. (2014). *Community-oriented policing to reduce crime, disorder and fear and increase satisfaction and legitimacy among citizens: A systematic review. Journal of Experimental Criminology*. Volume 10. 399-428.

24. С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн салбарын /Эрүүгийн эрх зүй, Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, Гэмт явдал судлал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн эрх зүй/ шинжлэх ухааны хөгжил, ирээдүйн чиг хандлага. *Эрдэм шинжилгээний өгүүлэл, Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүл*.

25. Ж.Долгорсүрэн. Д.Булган. (2014). *Монгол Улсын цагдаагийн эрх зүйн курс*. 23 дахь тал.

26. Б.Энхболд, Б.Мөнхдорж, Д.Сумьяацэрэн, Б.Мөнхсэргэлэн. (2017). *Монгол Улс дахь цагдаа судлалын төлөв байдал судалгааны тойм. Гэмт явдалтай тэмцэх асуудал" онол, арга зүй сэтгүүл*. №2.

27. С.Гантулга, Б.Энхболд. (2018). *"Эрдэм шинжилгээний өгүүлэл бичихэд анхаарах асуудал", Уб., Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүл*. №3.

28. Б.Энхболд. (2018). *"Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээ-2017"* судалгааны тайлан.





МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ САХИУЛАХ
ХАМГААЛАХ ЯАМ

ИРГЭНИЙ ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙН ХӨТӨЛБӨР, ОНЦЛОГ (ХАВСРАЛТ №1)

№	Улс	Их, дээд сургуулийн нэр	Хөтөлбөрийн нэр	Хөтөлбөр хэрэгжүүлэх үндэслэл	Төгсөгчийн ажлын байр
1.	АНУ	Цинциннатигийн Их сургууль	Criminal Justice	- Хууль сахиулах салбараар суралцах эрэлт хэрэгцээ - Гэмт хэргтэй тэмцэх тогтолцооны талаар шинжлэх ухааны олон хандлагаар (хууль зүй, социологи, сэтгэл судлал, удирдахуй) цогц байдлаар тайлбарлах хэрэгцээ шаардлага тогтмол үүсдэг; - Хууль сахиулах салбарын мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх; - Хууль сахиулах салбарын талаарх олон нийтийн мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх, - Гэмт хэргтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг хууль сахиулах байгууллага олон нийтийн оролцоотойгоор амжилттай шийдвэрлэдэг	✓ Цагдаагийн алба хаагч, мөрдөн байцаагч ✓ Олон нийтийн аюулгүй байдлын ажилтан ✓ Онцгой байдлын алба хаагч ✓ Цагдаа, онцгой байдал, аюулгүй байдлын зөвлөх ✓ Эрүүгийн эрх зүй, цагдаа судлалын багш ✓ Шинжээч, судлаач ✓ Төрийн захиргааны алба хаагч ✓ Хувийн хамгаалалтын албаны ажилтан ✓ Тагнуулын байгууллагын алба хаагч ✓ Шүүх эмнэлгийн шинжилгээ, хэргийн газрын шинжээч ✓ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч ✓ Засан хүмүүжүүлэх төвийн ажилтан, сэтгэл зүйч
		Жон Жэй Эрүүгийн хууль зүйн коллеж	Criminal justice and police administration Science in Protection Management		
		Мичиган мужийн их сургууль	Criminal Justice Law Enforcement Intelligence and Analysis		
		Зүүн хойд их сургууль	Criminal Justice Leadership		
		Мэрилэндийн их сургууль, Коллеж Парк	Criminology and Criminal Justice		
		Флорида мужийн их сургууль	Criminology and Criminal Justice		
		Аризона мужийн их сургууль	Criminal Justice and Criminology and Arts in Criminal Justice		
2.	БНСУ	Донггук Их сургууль	Police Administration	- Хууль сахиулах салбарын талаарх олон нийтийн мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх, - Гэмт хэргтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг хууль сахиулах байгууллага олон нийтийн оролцоотойгоор амжилттай шийдвэрлэдэг	✓ Цагдаагийн алба хаагч, мөрдөн байцаагч ✓ Олон нийтийн аюулгүй байдлын ажилтан ✓ Онцгой байдлын алба хаагч ✓ Цагдаа, онцгой байдал, аюулгүй байдлын зөвлөх ✓ Эрүүгийн эрх зүй, цагдаа судлалын багш ✓ Шинжээч, судлаач ✓ Төрийн захиргааны алба хаагч ✓ Хувийн хамгаалалтын албаны ажилтан ✓ Тагнуулын байгууллагын алба хаагч ✓ Шүүх эмнэлгийн шинжилгээ, хэргийн газрын шинжээч ✓ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч ✓ Засан хүмүүжүүлэх төвийн ажилтан, сэтгэл зүйч
		Кёнгги Их Сургууль	Police Administration and Public Safety		
		Ханнам Их сургууль	Police Administration		
3.	ХБНГУ	Төрийн удирдлагын хэрэглээний шинжлэх ухааны их сургууль	Arts in Public Administration with a focus on Police Management.	- Хууль сахиулах салбарын талаарх олон нийтийн мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх, - Гэмт хэргтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг хууль сахиулах байгууллага олон нийтийн оролцоотойгоор амжилттай шийдвэрлэдэг	✓ Цагдаагийн алба хаагч, мөрдөн байцаагч ✓ Олон нийтийн аюулгүй байдлын ажилтан ✓ Онцгой байдлын алба хаагч ✓ Цагдаа, онцгой байдал, аюулгүй байдлын зөвлөх ✓ Эрүүгийн эрх зүй, цагдаа судлалын багш ✓ Шинжээч, судлаач ✓ Төрийн захиргааны алба хаагч ✓ Хувийн хамгаалалтын албаны ажилтан ✓ Тагнуулын байгууллагын алба хаагч ✓ Шүүх эмнэлгийн шинжилгээ, хэргийн газрын шинжээч ✓ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч ✓ Засан хүмүүжүүлэх төвийн ажилтан, сэтгэл зүйч
		Дюссельдорф дахь Хэрэглээний Шинжлэх Ухааны Их Сургууль	Public Administration with a focus on Security Management.		
4.	Их Британи Улс	Портсмутын их сургууль	Police and Criminal Justice Studies	- Хууль сахиулах салбарын талаарх олон нийтийн мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх, - Гэмт хэргтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг хууль сахиулах байгууллага олон нийтийн оролцоотойгоор амжилттай шийдвэрлэдэг	✓ Цагдаагийн алба хаагч, мөрдөн байцаагч ✓ Олон нийтийн аюулгүй байдлын ажилтан ✓ Онцгой байдлын алба хаагч ✓ Цагдаа, онцгой байдал, аюулгүй байдлын зөвлөх ✓ Эрүүгийн эрх зүй, цагдаа судлалын багш ✓ Шинжээч, судлаач ✓ Төрийн захиргааны алба хаагч ✓ Хувийн хамгаалалтын албаны ажилтан ✓ Тагнуулын байгууллагын алба хаагч ✓ Шүүх эмнэлгийн шинжилгээ, хэргийн газрын шинжээч ✓ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч ✓ Засан хүмүүжүүлэх төвийн ажилтан, сэтгэл зүйч
		Лестерийн их сургууль	Police Leadership and Management		
5.	БНФУ	Парисын их сургууль 1 Пантеон-Сорбонн	Public Administration with a specialization in Security and	- Хууль сахиулах салбарын талаарх олон нийтийн мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх, - Гэмт хэргтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг хууль сахиулах байгууллага олон нийтийн оролцоотойгоор амжилттай шийдвэрлэдэг	✓ Цагдаагийн алба хаагч, мөрдөн байцаагч ✓ Олон нийтийн аюулгүй байдлын ажилтан ✓ Онцгой байдлын алба хаагч ✓ Цагдаа, онцгой байдал, аюулгүй байдлын зөвлөх ✓ Эрүүгийн эрх зүй, цагдаа судлалын багш ✓ Шинжээч, судлаач ✓ Төрийн захиргааны алба хаагч ✓ Хувийн хамгаалалтын албаны ажилтан ✓ Тагнуулын байгууллагын алба хаагч ✓ Шүүх эмнэлгийн шинжилгээ, хэргийн газрын шинжээч ✓ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч ✓ Засан хүмүүжүүлэх төвийн ажилтан, сэтгэл зүйч



МОНГОЛЫН
ИХ ХАМГААГАХ
ЯМ АХУЙН
ТӨР
УДИРДЛАГЫН
АКАДЕМИ

			Crisis Management.		
		Лионы их сургууль 3 Жан Мулин	Public Law and Public Administration with a focus on Security and Law Enforcement. (k, aerg)		
6.	Испани Улс	Алсын боловсролын их сургууль	Criminal Law and Criminal Justice		
		Мадридын Комплютенсийн их сургууль	Security and Police Management		
7.	БНХАУ	Бээжингийн багшийн их сургууль	Law and Public Administration		
		Зүүн Хятадын Улс төр, хуулийн их сургууль	Criminal Justice		
		Нанжингийн Шинжлэх ухаан технологийн их сургууль	Law with specializations in criminal justice and police management.		
8.	ОХУ	Москвгийн Улсын Их Сургууль	Criminal justice and law enforcement		
		Оросын ардын аж ахуй, төрийн удирдлагын академи	Security and law enforcement		
		Санкт-Петербург улсын их сургууль	Criminal law and criminology		
9	Япон Улс	Токио хотын их сургууль	Criminology and public safety		
		Васэда Их сургууль	law and criminal justice studies		
		Осакагийн Их сургууль	Policing, criminal behavior, and justice systems.		